

**ХЯТАДЫН НИЙГЭМ  
ЭДИЙН ЗАСГИЙН  
ШИНЭЧЛЭЛТИЙН ЗАРИМ  
АСУУДАЛ, ТУРШЛАГА**

**Д. Баясгалан**

БНХАУ-ын нийгэм эдийн засгийг өөрчлөн шинэчлэх үйл явц нь аж үйлдвэржих замаар өрнөн хөгжиж, хөдөө аж ахуйг өөрчлөн зохион байгуулж, ард олныхоо оюуны соёлыг баяжуулж байгаагаараа үр дүнгээ өгч дэлхий нийтийн анхаарлыг татах болсон юм.

1978 онд хуралдсан ХКН-ын 11 дэх удаагийн III бүгд хурал Хятад орны нийгэм эдийн засгийн системийг өөрчлөн шинэчлэх зорилтыг анх дэвшүүлснээрээ улс орныхоо хөгжилд чухал үе шатыг нээсэн юм. Намын ажлын зонхилох хэсгийг аж ахуйг боловсронгуй болгон хөгжүүлэх стратеги зорилтод захируулах улмаар социалист шинэчлэлтийг бүх талаар хэрэгжүүлэх зорилтыг дэвшүүлснээр тэр үеэс эдийн засгийн шинэчилсэн бодлого боловсруулан хэрэгжүүлэх, хэт үзэл сурталчилсан байдлаас зайлсхийж, бодит байдал, туулж ирсэн хөгжлийн түүхэн туршлага, түүнээс гарсан сургамжууддаа зохих дүгнэлт хийж, улс орныхоо хөгжлийн ирээдүйд зохицох бодлого боловсруулах эрэл хайгуулыг зоригтой туршиж эхэлсэн билээ.

ХКН-ын XII их хурлаас Хятадын өвөрмөц онцлогтой социализмын загварыг бий болгох тухай заасан ба эдийн засгийн шинэтгэлийн онолын үндсэн томъёололыг 1988 онд хуралдсан 13 дахь удаагийн III бүгд хурлаас «Нийгмийн өмчид үндэслэсэн төлөвлөгөөт таваарын аж ахуй бол социалист аж ахуй байх юм»<sup>1</sup> гэж тодорхойлсон юм. ХКН-ын XIII их хурал улс орноо социализмын замаар тууштай хөгжүүлэх туршлага, сургамжийг дүгнэн үзэж, нийгмийн амьдралын бүх салбарыг хамарсан эдийн засаг, улс төрийн системээ шинэчлэх шинэчлэлтийг цаашид улам гүнзгийрүүлэх алс хэтийн программыг хэрэг жүүлэхэд нэгэн алхам болгож зуун жил үргэлжлэх хугацаатай социализмын эхэн шат хэмээх онолын дүгнэлтийг боловсруулан тавьсан юм.

Социализмын эхэн шат хэмээх энэ ухагдахууныг Хятадын нийгэм судлаачид 1-рт: Манай нийгэм бол социалист нийгэм учраас социализмын зарчмыг чанд сахина- 2-рт: Манай улс социалист нийгмийн хөгжлийн эхэн шатанд байгаа ба түүнийг алгасан хөгжих боломжгүй юм гэхийн зэрэгцээ «Энэхүү социализмын эхэн шат бол аливаа улс орнууд социализмын замруу орж хөгжих үеийн эхэн үе биш бөгөөд Хятадын хувьд онцлогтой үе юм. Үйлдвэрлэх хүчин хоцрогдсон, таваарын аж ахуйн хөгжил буурай байгаа нөхцөлд социализмыг бүрэн төгс байгуулахад бид энэ үе шатыг зайлшгүй туулж гарах ёстой юм... Энэ үе шат социалист эдийн засгийн үндэс тавигдаагүй шилжилтийн үеэс ялгаатай төдийгүй социалист шинэчлэл дуусах үеэс ч бас ялгаатай юм. Энэ үеийн гол зөрчил бол- ард түмний өсөн нэмэгдэж байгаа материаллаг болон оюуны хэрэгцээ ба нийгмийн үйлдвэрлэл хоцрогдож буйн хоорондын зөрчил байна. Гол зөрчлийг бодитойгоор шийд вэрлэхийн тулд таваарын аж ахуйг бүх талаар хөгжүүлэх, хөдөлмөрийн бүтээмжийг дээшлүүлэх, аж үйлдвэр, хөдөө аж ахуй, үндэсний

батлан хамгаалах, шинжлэх ухаан, техникийн салбарт шинэчлэлтийг тууштай хэрэгжүүлэх явдал мөн»<sup>2</sup> гэж үзэж байна.

Социализмын эхэн шатны мөн чанарыг хятадын эдийн засагчид «Үйлдвэрлэх хүчний харилцаа бүхэлдээ доогуур байгаа ба үйлдвэрлэлийн харилцаа нь эдийн засгийн олон хэвшлүүд, хуваарилалтын янз бүрийн аргаар зэрэгцэн оршиж байгаа нөхцөл зэргээс уялдан гарч байгаа юм»<sup>3</sup> гэж тайлбарлаж байна.

Социализмын эхэн шатны тогтолцоот үзэл, хятадын өвөрмөц онцлогтой социализмыг байгуулах ХКН-ын үндсэн чиг шугам нь түүхэн тодорхой нөхцөлд Хятад оронд өрнөж байгаа социализм байгуулалтын үйл явцын ололт, дутагдлын талаар олон талт судалгаа, дүгнэлт хийж байгаагаараа социализмын орнуудад сургамжтай бөгөөд шинжлэх ухааны социализмын онолыг өөрийн өвөрмөц байдалд бүтээлчээр хөгжүүлж, хувь нэмрээ оруулж буй хэрэг гэж эрдэмтэд, судлаачид үзэж байна.

Хятадын социализмын эхэн шат хэмээх томъёоллоос эн түрүүнд уламжлалт, хуучин эдийн засгийн системийг зайлшгүй өөрчлөх явдал урган гарч ирсэнтэй холбогдон улс төрийн системд ч өөрчлөлт гарсан юм.

Хятадын улс төрийн системийн шинэчлэлтийн гол зорилго нь нам ба засаг захиргааны байгууллагуудын үүргийг ялган зааглах явдлаас эхэлжээ. ХКН-ын XIII их хурал дээр тэмдэглэсэнээр намын байгууллагууд үйлдвэр, аж ахуйн газруудыг ажлаар хангаж, хяналтаа хэрэг жүүлэхээс бус урьдын адил «нэгдмэл» удирдлагаар ажлыг хэрэгжүүлэхгүй болжээ<sup>4</sup>.

Орон нутгийн намын бүх шатны байгууллагын сонгуульд захиргааны ажилтнуудыг сонгохгүй байхаар зохицуулснаас гадна урьд намын дээд байгууллагын мэдэлд байсан намын анхан шатны байгууллагуудыг тухайн орон нутгийн намын байгууллагын мэдэлд нь шилжүүлжээ. Мөн намын хяналтын комиссууд зөвхөн намын сахилгыг зөрчсөнтэй холбогдох хэргийг л шүүн хэлэлцэж байхаар тогтоожээ.

Ардын төлөөлөгчдийн байнгын хороо нь ардын хурлын бүрэн эрхийг барьж, сонгуулийн системийг ардчилах замаар байгаа ба сонгуулийн шинэ хууль боловсруулан мөрдөж байна.

Хятад орны улс төрийн системийг шинэчлэхэд удирдлагын төвлөн удирдах явдлыг багасгахад ихээхэн анхаарч байна. Энэ асуудал удирдлагын аппаратын өөрийнх нь өөрчлөлттэй холбоотой тул юуны өмнө удирдлагын янз бүрийн байгууллагуудыг нэгтгэн цомхотгох арга хэмжээ авч байгаагийн дүнд 98 яам, тусгай газрыг 52 болгон цомхотгож, сайд, орлогч сайд нарын тоо 77%-иар хорогджээ. Нийгмийн амьдралыг бүхэлд нь ардчилахад ард олны болон нийгмийн олон үе давхаргуудын эрх ашиг, сонирхолыг илэрхийлсэн ил тод байдлыг хөгжүүлэх нөхцөлийг бий болгоход анхаарч байгаагийн зэрэгцээ социалист хууль ёс, дэг журмыг ихээхэн бэхжүүлж байна. Зөвхөн 1978— 1987 онуудад 60 гаруй хууль зүйн баримт бичгийг шинээр боловсруулжээ. Улс төрийн системийн шинэтгэлийн нэг чухал чиглэл нь боловсон хүчний талаар баримтлах бодлого ба улсын бүх албан хаагчдыг засаг захиргааны ба мэргэжлийн ажилтнууд гэж хуваан үздэг болсон бөгөөд эдийн засгийн шинэчлэлийг хэрэгжүүлэхэд боловсон хүчний бодлогод өөрчлөлт хийх зүй ёсны шаардлага гарч байгаа юм.

ХКН-ын XIII их хурал эдийн засгийн шинэчлэлтийг хэрэгжүүлэх механизмын шинэ хэлбэрийг «Улс зах зээлийг зохицуулна, зах зээл үйлдвэр, аж ахуйн газрын ажлыг тодорхойлно»<sup>5</sup> гэж тэмдэглэсэн юм.

Хятадын эдийн засгийн шинэтгэлийн үндсэн бодлого нь төлөвлөлт, удирдлагын хэт төвлөрсөн системээс ухарч, захиран тушаах аргыг эдийн засгийн зохицуулалтаар солих, эдийн засгийн урамшууллыг тэргүүн зэрэгт тавих, дотоод, гадаад нөөц бололцоог бүрэн ашигласан аж ахуйн бүх төрлийн ажиллагааг хөгжүүлэхтэй холбоотой юм. Иймээс ч эдийн засгийн шинэчлэлт нь юуны өмнө аж ахуйн салбаруудыг хүнд суртлаас чөлөөлж, эрхийг нь өргөтгөх ардчилсан боломж нөхцөлөөр ханган, гадаад улсуудтай эдийн засгийн нээлттэй бодлого явуулах зэрэг арга хэмжээнээс эхэлжээ.

Шинэтгэл хийх, дэлхий дахинд нээлттэй байх нь социалист системийг өөрийг нь боловсронгуй болгох, давуу талыг нь цаашид илрүүлэх зорилготой ба төлөвлөгөөт эдийн засгийг зах зээлийн зохицуулалттай зөв хослох нь улс орны эдийн засгийг өөрчлөн байгуулах үндсэн зарчим гэж үзэн шинэчлэлтийн эхний алхамыг хөдөө тосгоноос эхэлж туршжээ. Тариачны хөдөлмөрийн үр дүнг орлоготой нь шууд холбон турших өрхийн гэрээний ажлын үр дүнд 1983 онд гэхэд л тариачдын аж ахуйн 97% хамрагдан ихээхэн үр дүнгээ өгчээ. Үүнтэй уялдан хотын хүн амыг хүнсний бүтээгдэхүүнээр хангах, үйлдвэрийг хөдөө аж ахуйн түүхий эдээр хангах явдал эрс сайжирчээ. Гэвч, гэрээ түрээс нь богино хугацаатай байсан нь хүссэн үр ашгаа өгдөггүйг практик нотолж өгснөөр одоо Хятадад түрээсийн хугацааг эхний үед 10-15 жил байсныг өөрчлөн 30—50 жил, түүнээс илүү хугацаагаар ч сунгасан байна.

БНХАУ-д эдийн засгийн системийн шинэтгэлийн явцад хийсэн бас нэгэн шийдвэртэй алхам бол хотод аж ахуйн үйл ажиллагааны хувийн болон хамтын хэлбэрийг хөхүүлэн дэмжсэн явдал юм. Улсын жижиг үйлдвэрийн газрыг зарим хүмүүст гэрээ, түрээсээр өгөх юм уу, тэдэнд худалдсанаар жижиг үйлдвэрүүд ихээхэн үр ашигтай ажиллах болжээ. Үүний зэрэгцээ улсын үйлдвэрийн газрын өмчийн эрхийг дахин хуваарилаж болох хэлбэр бол хувь нийлүүлсэн систем гэж үзсэн юм.

Гадаадын хөрөнгө оруулагчидтай хамтран ажиллах салбарт үйлдвэрлэлийг хорших, өөрөөр хэлбэл, гэрээгээр хамтын үйлдвэр байгуулах асуудал чухал байр эзэлж байна. Хамтарсан үйлдвэрийн газарт нэлээд хөнгөлөлттэй татвар оногдуулсан төдийгүй дээд хэмжээг нь ч хязгаарлаагүй юм. Мөн бүхэлдээ гадаадын капиталд тулгуурласан үйлдвэрийн газар байгуулж болохыг зөвшөөрчээ.

Хамтарсан үйлдвэр байгуулах хамтын ажиллагааны энэ хэлбэр нь гадаадын санхүү, материал, технологийн болон удирдлагын бололцоог иж бүрэн ашиглах боломж олгодог ороо хятадын талын сонирхлыг ихэд татаж байна. Өөр нэгэн анхаарал татаж буй зүйл бол бусдын түүхий эд, материалыг боловсруулж өгөх болон зардлаа бүтээг дэхүүнээрээ нөхөн төлөх худалдааны хэлбэрээр хамтын ажиллагааг өргөжүүлж буй явдал юм. Мөн эдийн засгийн шинэтгэлийг хэрэгжүүлэхэд үлэмж хэрэгтэй орчин үеийн тоног төхөөрөмж худалдан авахад зайлшгүй шаардагдах хатуу валюттай болох талаар олон талын арга хэмжээ авч байна. Зөвхөн 1988 оны байдлаар гэхэд л хилийн чанадад 168 үйлдвэрийн газар нээж ажиллуулах зорилгод 150 сая долларын хөрөнгө оруулжээ. Одоогоор хилийн чанадад хятадын өөрийнх нь болон хамтарч байгуулсан үйлдвэрийн тоо 600 гаруй болоод байна.

1989 онд хуралдсан ХКН-ын ТХ-ны IV бүгд хурал «эдийн засгийн шинэ журмыг бэхжүүлэх, шинэчлэлийг гүнзгийрүүлэх чиг шугамыг тууштай баримтлах»<sup>6</sup> явдлыг бататгасан билээ. Ийнхүү хятадын эдийн засгийг шинэчлэх үйл явц эрчээ аван үргэлжилсээр байгаа төдийгүй

өнгөрсөн арав гаруй жилд улс ардын аж ахуйн хөгжлийн үндсэн үзүүлэлт нь мэдэгдэхүйц өсөж, аж үйлдвэрийн бүхэл бүтэн систем байгуулагдан, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд үндсэн өөрчлөлт гарч, гадаад дотоод худалдаа эрчимтэй хөгжиж, шинжлэх ухаан, соёл, боловсролын хүрээнд их амжилт олж, ард түмний нь амьдралын түвшин ихээхэн нэмэгдлээ. БНХАУ үр тариа, мах, хөвөн, цемент нүүрс үйлдвэрлэлээр богино хугацаанд дэлхийд тэргүүн байранд гарч, ган, нефть, эрчим хүч гаргалтаар IV-V байр эзлэх болов. Дээрх хугацаанд нийгмийн нийт бүтээгдэхүүний жилийн дундач өсөлт 9,3, аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүн 12, хөдөө аж ахуйн нийт бүтээгдэхүүн 6,5 гадаад худалдааны эргэлт 17 хувь өслөө.

Үр тарианы үйлдвэрлэл 1978 онд 305 сая тонн байснаас 1988 онд 402 сая тонн болон өссөн ба тариачдын бодит орлого 2,8 дахин нэмэгдсэн байна. Товчхон тэмдэглэхэд энэ хэдхэн жилд тэрбум гаруй хүн амтай хятад орныг хооллож, хувцаслах асуудлыг бүрэн шийдвэрлэсэн нь шинэчлэлтийн түүхэн гавьяатай хэрэг болсон ба үүнийг хэрэгжүүлсэн нийгэм эдийн засгийн гол хүчин зүйл нь аж ахуйн шинэчлэлт ба эдийн засгийн гадаад харилцаанд нээлттэй бодлого баримталсаны үр шим гэж хятадад дүгнэн үзэж байна. Ер нь ч «аж ахуйн шинэчлэлт-нээлттэй харилцаа» гэсэн нэгдмэл хоёр зүйл БНХАУ-ын 80-аад оны шинэчлэлтийн гол төгөлдөр утга болж байгаа нь тодорхой. Гэсэн хэдий ч хятад улс эдийн засгийн хоцрогдолтой хэвээр үлдэж байгаа ба хүн амд ноогдох үндэсний орлогын хэмжээ зэрэг үндсэн үзүүлэлтүүдээр ЗХУ, АНУ, Япон, ХБНГУ, Франц, Англи зэрэг эдийн засгийн өндөр хөгжилтэй орнуудаас мэдэгдэхүйц хоцорч байна.

Иймээс ч шинэчлэлтийг эдийн засгийн хөгжлийн сул, дорой байдлаас эрчимтэй хөгжлийн замруу эргэлт хийх чиглэлээр хэрэгжүүлж байгаа ба ингэснээр энэ зууны эцэс гэхэд Хятад орныг дунд зэргийн хөгжилтэй орны түвшинд хүргэхийн тулд нэг хүнд ноогдох үндэсний орлогыг 800 — 1000 долларт хүргэх буюу одоогийнхоос 1,6-2 дахин нэмэгдүүлэх зорилт тавьж байгаа билээ.

Эдийн засгийн шинэчлэлийн хэрэг эрхэлдэг улсын комиссоос онолын маргаантай сэдвүүд тухайлбал, төлөвлөгөө ба зах зээл, шинэчлэлтийн загварууд, өмчийг шинэчлэх, шинэчлэлтийн оньсон чиглэлүүд, хувь нийлүүлгийн систем, гэрээний систем, хөлсний хөдөлмөр зэрэг асуудлаар маргаан ярилцлага өрнүүлж улс орныхоо эдийн засгийг шинэчлэх асуудалд хариу өгч байгаа ба энэхүү үйл явц дунд олон хурц асуудал, зөрчил үүсч байгаагийн гол шалтгааныг эдийн засгийн хуучин механизм задарч, шинэ механизм бүрэн бүрэлдэж чадаагүй байгаатай холбон үзэж байна.

Эдийн засагт шинэчлэлт өрнөн хөгжихөд хэдэн үе шатыг туулах юм гэж хятадын судлаачид үзэж байна. 1979-1985 оныг хүртэлх эхэн үед шинэчлэлтийг түгээн дэлгэрүүлэх, эрэлт хайлт хийх, туршин сорих, туршлага хуримтлуулах явдал өрнөсөн юм.

2-р үе буюу 80-аад оны II хагас дахь эдийн засгийн шинэтгэлийн үндсэн чиглэл нь онолын боловсруулалт хийх ба эхэн үеийн практик шалгуур дээр үндэслэн цаашдын хөгжил рүү алхам хийсэн явдал болж байна.

3-р үе буюу 1991—2050 онуудад «шийдвэрлэх гол зорилт» бол үнийн систем, үнэ бүрдэлтийн механизмыг өөрчлөх явдал хийгээд үүнийг шийдвэрлэхгүйгээр аж ахуйн механизм үндсээрээ өөрчлөгдөх аргагүй юм гэж үзэж байна. Хамгийн хүнд зорилтыг 2050 онд хэрэгжүүлсэн байх бөгөөд тэр үед нийгмийн нийт бүтээгдэхүүнийг 4 дахин нэмэгдүүлэх юм. Тэгэхэд нэг тэрбум таван зуун сая хятад хүн ам тутамд 4000 доллар оногдох ажээ.

Ийнхүү нийгэм эдийн засагт хийгдэж буй шинэчлэлтийн явцад хятад улс нэлээд туршлага хуримтлуулсан бөгөөд бусдын туршлагаас ч идэвхтэй суралцаж өөрийн орны хөгжлийн өвөрмөц онцлогт тохируулан хэрэгжүүлж байгаа нь ихээхэн ач холбогдолтой болохыг практик харуулсаар байна.

БНМАУ-д өрнөж буй өөрчлөлт, шинэчлэлтийн цар хүрээ чалхам, алхамаар өргөжин, эдийн засаг, нийгэм, улс төр, хүмүүсийн оюун санааг хамран манай орны амьдрал, үйл ажиллагааг тодорхойлогч шинжтэй болж байна. Гадаад улс төр, гадаад эдийн засгийн үйл ажиллагааны харилцан шүтэлцээ, нэгдмэл чанарын үр өгөөжийг амьдралд бодитойгоор хэрэгжүүлэх, гадаад эдийн засгийн харилцаан дахь за хиргаадан тушаах аргыг эдийн засгийн аргад тулгуурлан өөрчлөн явуулах нь илүү үр дүнд хүрч болохыг социалист орнуудад шинэчлэлтийг хэрэгжүүлж буй хөгжлийн явц практикаас тодорхой харагдаж байгаа билээ. Иймээс манай улсын өөрчлөн байгуулалтын үйл ажиллагаанд социалист бусад орны, түүний дотор олон зуун жилийн түүх, соёлын их харилцаатай, хөрш зэргэлдээ орших Хятадын туршлагаас судлах, харилцан суралцах зүйл цөөнгүй байгаа ба энэ талаар хамтран ажиллах явдал нэн чухал шаардлагатай болж байна.

Хөдөө аж ахуйд шинэ маягийн зохион байгуулалт хийж, хөдөлмөрийн хөлс олгох журмыг боловсронгуй болгох, банк зээлийн системийг өөрчлөх, төвийн болон орон нутгийн төсвийн харилцааг зохицуулах, орон нутагт аж ахуйн тооцооны эхлэлийг бий болгож боловсронгуй болгон хөгжүүлэх, үйлдвэрлэлийн хэрэгслийг бөөнөөр худалдах явдлыг нэмэгдүүлэх зэрэг арга туршлага нь манай эдийн засагчдын анхаарлыг зүй ёсоор татаж байгаа билээ. Мөн хятадын эдийн засгийн гадаад харилцаан дахь нээлттэй бодлогын хүрээнд хийгдэж буй хамтын үйлдвэрлэлийг зохион байгуулах, гадаадын хөрөнгө оруу лалтыг шууд татан орлцуулах, хамтарсан үйлдвэр, аж ахуйн газрыг хууль эрх зүйн дагуу зохион байгуулах зэрэг ажлуудыг судалж үзэх нь чухал юм. 1979 онд анхныхаа хуулийг батлан гадаадтай хамтарсан үйлдвэр байгуулахыг зөвшөөрснөөс хойш өнөөг хүртэл Хятадад 20 шахам мянган үйлдвэрийн газар түүний дотор, хятад гадаадын капиталд тулгуурласан таван мянга гаруй үйлдвэр байгуулагдаад байна. Үүнтэй уялдан эдийн засгийн гадаад харилцаатай холбоотой олон зуун хууль эрхийн баталгаа баримт бичгийг боловсруулсан ба дахин 150 гаруй ийм баримт бичиг боловсруулахаар төлөвлөөд байгаа ажээ.

МАХН-ын ТХ-ны VII бүгд хурал манай улсын эдийн засгийн гадаад харилцааны нээлттэй бодлогыг тунхаглан улмаар социалист орнуудтай хамтын ажиллагаагаа өргөтгөхийн хамт, дэлхийн аж ахуйн харилцааны түгээмэл зарчмуудаас суралцахыг заасан нь цаг үеэ олсон зарчмын ач холбогдолтой шийдвэр болж байна. Тиймээс манай орнуудад өрнөж байгаа цар хэмжээгээр асар их, ач холбогдлоороо хувьсгалт шинэчлэлт нь өөр хоорондын маань харилцаанд ч шинэ шаардлага тавьж байгааг харгалзан шинэчлэлтийн явц дахь туршлага, сургамжуудыг нарийвчлан судалж, өөрийн орны өвөрмөц нөхцөл, хөг жилд тохирсон бодлогыг боловсруулан амьдралд тууштай хэрэгжүүлэх нь манай улсын хөгжин дэвжихэд ихээхэн ач холбогдолтой болох билээ

<sup>1</sup> ХКН-ын ХҮЛ их хурал ба Хятад дахь шинэчлэлт. Бээжин. ,1987., 22-р тал

<sup>2</sup> Проблемы Дальнего Востока. Москва., 1989, No 1, 56-р тал

<sup>3</sup> Жэньминь жибао., 1987.2.1

<sup>4</sup> ХКН-ын XIII их хурлын баримт бичгүүд. Бээжин, 1988, 58, 63, 69-р талууд

- <sup>5</sup> Правда. 1988.7.31  
<sup>6</sup> Баньюэ Тан. 1987. No 1., 33-р тал  
<sup>7</sup> Гуанминь жибао. 1987.2.23  
<sup>8</sup> Бээжин ревью. 1987. No 3., 21-р тал  
<sup>9</sup> Жэньминь жибао. 1985.5.11  
<sup>10</sup> Хуньци. 1982., No 10, 30--31-р тал  
<sup>11</sup> Хятадын тоо бүртгэлийн түүвэр., Бээжин., 1986., 124, 223-р тал  
<sup>12</sup> Жэньминь жибао. 1988. 11.26.  
<sup>13</sup> ХКН-ын ХП их хурал. Бээжин ., 1982  
<sup>14</sup> Жэньминь жибао., 1989.11.12  
<sup>15</sup> Реформа хозяйственной системы в КНР. Москва., 1989

### **АЗИ-НОМХОН ДАЛАЙН БҮС НУТАГ ДАХЬ АНУ-ЫН БОДЛОГО: ЗАЛГАМЖ ЧАНАР, ШИНЭ ЗҮЙЛ**

**Х. Хулан**

Ази-Номхон далайн бүс нутаг (АНДБН) дахь АНУ-ын бодлого, нөлөө нь түүний газарзүй, стратегийн байдал, хүчин чадлаараа уг бүс нутгийн олон улсын улс төр, эдийн засгийн бүтцэд гол байр суурь эзэлдэгээр тодорхойлогдоно. Америкийн бодлогын бүрэлдэхүүн хэсэг бол дэлхий дахиныг хамарсан стратегийн элемент, бүс нутаг дахь гол төлөв улс төр, эдийн засгийн сонирхол, улс орнуудтай байгуулсан хоёр талын харилцаа юм. Гэхдээ АНУ-ын бодлого энэхүү хэсгүүдийн жирийн нийлбэр төдий биш, харин бүс нутаг дахь улс төрийн нэгдмэл гадаад стратеги билээ. Энэ стратеги нь эрчимтэй хөгжиж, дэлхий дахины бодлогод нэн чухал ач холбогдолтой болж байгаа бүс нутагт АНУ-ын цэрэг улс-төрийн болон эдийн засгийн нөлөөг бэхжүүлэх зорилго агуулж байна.

АНУ-ын стратегийг тодорхойлоход ач холбогдолтой АНДБН-ийн олон улсын харилцааны үндсэн хандлага ямар болохыг цэгнэж үзэхийг оролдъё. Нэгдүгээрт, АНДБН-ийн гол гол улсуудын хоорондын харилцаа шилжилтийн урсгал байдалтай бөгөөд холбоотны тодорхой бүтэц тогтоогүй байна. Ийм тодорхой биш байдалтай боловч бүс нутагт цэрэг-улс төрийн болон үзэл суртлын хурцадмал байдал намжих үндсэн хандлагатай. Үүнд тус дөхөм болж байгаа нэгэн хүчин зүйл бол АНУ, ЗХУ, Хятад, Япон зэрэг эндэхийн гол орнуудад эдийн засаг, нийгмийн хувьд шинэчлэл гүнзгийрч, зарим талаар бүтцийн чанартай болж байна. Иймээс тэд эд материалын ихээхэн зардал, цэрэг улс төрийн осолтой үйлдэг шаардахгүй. хянамгай бодлого явуулах хэрэгцээтэй тулгарч байна.<sup>1</sup>

Бүтцийн шинж бүхий бас нэг хандлага гэвэл аж үйлдвэрийн шинэ орнууд эдийн засгийн талаар өрнүүн өсч, худалдааны чиг шугам өөрчлөгдөн, цахим хүчний болон дэд бүтцийн цоо шинэ салбарууд асар их хөгжиж байгаагийн улмаас бүс нутгийн орнууд Номхон далай даяар харилцан үйлчлэх болов. Ингэж үйлчлэхэд бүс нутгийн орнуудын харилцаа «азичлагдаж», уг бүсээс гадуур оршдог гүрнүүдийг түшиглэж